

## Менежментийн захидал

Аймгийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Баацагаан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Баацагаан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



# ГУРВАНБУЛАГ СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор\*  
Е.Сугаррагчаа  
Утас: 70442584  
Цахим  
хаяг sugar\_bhr1989@yahoo.com

Аудитын менежер:  
Д.Цэцэгмаа  
Утас: 70442424  
88089024  
Цахим хаяг:  
tsetsegmaa\_1961@yahoo.com

Шинжээч Б.Цэрэнчимэд  
Утас: 88302569  
Цахим хаяг:  
b.tserenchimed@yahoo.com

## Менежментийн захидал

### Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1  
Мөнгөн хөрөнгө .....1

2

тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Гурванбулаг сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ё.СУГАРРАГЧАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
БАЯНХОНГОР АЙМГИЙН

АУДИТЫН ГАЗАР

64101 Номгон, Баянхонгор сум

Утас, факс 70-44-25-84

E-mail: bayankhongor@audit.gov.mn

ГУРВАНБУЛАГ СУМЫН  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН  
ЗАХИРАГЧ Д.БАНЗРАГЧ  
ТАНАА

2016.03.11 № 166

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ Т

Аудитын гэрчилгээ

Гурванбулаг сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Аймгийн аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Гурванбулаг сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гурванбулаг сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон

<b>Асуудал 1: Мөнгөн хөрөнгө</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
----------------------------------	----------------------------------

**ААГ-ын ажиглалт**

- Төсвийн тухай хуулийн 58.4.1, Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалын 6.2 Сангийн сайдын 2014 оны 43-р тушаалын 7.4 дэх заалтыг зөрчин ОНХСангийн хөрөнгөөр багийн төвийн барилга барихад 11.3 сая төгрөг зарцуулжээ.

- Төсвийн тухай хуулийн 58.4.1, 60.3.4 заалтыг зөрчин иргэдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах нэрээр эм, урвалж хэрэгсэлд 9900.0 мянга, хууль зүйн өмгөөллийн ажлын хөлсөнд 2000.0 мянган төгрөг тус тус зарцуулжээ

**Эрсдэлүүд**

Хөрөнгө үрэгдэж шамшигдах.

**ААГ-ын зөвлөмж**

- ОНХСангийн хөрөнгийг зарцуулах аймгийн чиг, үүрэгт буюу Сангийн сайдын 2014 оны 43-р тушаалын 7.2.2.а "Орон нутгийн өмчийн барилга, байгууламж бий болгох, их засвар хийх" гэж заасан байхад сумын чиг үүрэгт хамааралгүй багийн барилга барьсан алдааг давтан гарагхгүй байх
- Төсвийн тухай хуулийн 60.3. "орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.1-т "Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга хэмжээ" санхүүжүүлэхгүй байх

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн менежер хүлээн зөвшөөрсөн болно.

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**

**ХЯНАСАН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

**БЭЛТГЭСЭН:**

ШИНЖЭЭЧ



Ё.СУГАРРАГЧАА Огноо:

Д.ЦЭЦЭГМАА Огноо:

Б.ЦЭРЭНЧИМЭД Огноо